



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 529

Улаанбаатар хот

### Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1.2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2020 оны төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшил, ашиглалт, захиран зарцуулалт, газар эзэмшил, ашиглалт, баталгаажуулалтын үйл ажиллагаанд хийсэн Улсын байцаагчийн баримтын шалгалтаар 765.4 (долоон зуун жаран таван сая дөрвөн зуун мянган) сая төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн яамны төрийн нарийн бичгийн дарга Ц.Эрдэмбилэг, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал Ш.Алтантуяа нарт санхүүгийн сахилга батыг хэвшүүлэх, дотоод хяналтыг сайжруулж дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай.

2.1. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг ханган ажиллах;

2.2. Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, төрийн өөрийн өмчид бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах;

2.3. Бусад орлогоор үндсэн хөрөнгө бэлтгэхдээ тухай бүр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авах;

2.4. Эх хүүхдийн эрүүл мэндийн төвийн төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээгүй ашиглуулж байгаа байр талбайд сонгон шалгаруулалт зарлаж, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн ажиллах;

2.5. Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлэг, Хүүхдийн эмнэлэг дотор зөвшөөрөлгүй түрээсэлсэн 19,38 м<sup>2</sup> талбайд ногдох түрээсийн төлбөрийн 40 хувь болох 1,395.00 (нэг сая гурван зуун ерэн таван мянган) төгрөгийг 2021 оны санхүүгийн жилд багтаан улсын төсөвт төвлөрүүлэх;

2.6. Хавсралтад дурдсан тавилга эд хогшил дансанд бүртгэлтэй, 37 нэр төрлийн, 396.4 сая (гурван зуун ерэн зургаан сая дөрвөн зуун мянган) төгрөгийн техник хэрэгслийг машин тоног төхөөрөмж (компьютер) дансны ангилалд залруулан бүртгэх ажлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх” журмыг үндэслэн шийдвэрлэх;

132001564

2.7.Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.


3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ  
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.ТҮВШИНЗАЯА

Эх хүүхдийн эрүүл мэндийн нэгдсэн эмнэлэгт хийсэн  
хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах  
арга хэмжээний жагсаалт

№	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /мян.төг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Тогтоолын хэрэгжилт хангаж ажиллах тухай	Захирал Ш.Алтантуяа Санхүү албаны дарга Д.Байгальмаа	216,200.0	ТӨБЗГазрын 2020 оны 5 сарын 05-ний өдрийн 188 дугаар тогтоолоор 216,2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө акталж устгах ажлыг зохион байгуулж тогтоолын хэрэгжилтийг ТӨБЗГазарт ирүүлэх.
2	Тавилга эд хогшлын дансанд буруу бүртгэсэн хөрөнгийг залруулж тухай.	Захирал Ш.Алтантуяа Санхүү албаны дарга Д.Байгальмаа	396,396.94	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 заалт, Улсын секторын НБББОУСтандартын 17 заасан Үндсэн хөрөнгийг ангилал зүйл заалтаар бүртгэлийг залруулж зөв бүртгэх./Техник хэрэгслийг тавилга эд хогшил дансанд бүртгэсэн/
3	Зөвшөөрөлгүй бүртгэсэн хөрөнгийн тухай.	Захирал Ш.Алтантуяа Санхүү албаны дарга Д.Байгальмаа	68,865.6	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 271 тогтоолыг мөрдөж ажиллах.
4	Үндсэн хөрөнгөд үнэлж бүртгэх тухай.	Захирал Ш.Алтантуяа Санхүү албаны дарга Д.Байгальмаа	83,900.0	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 заалт, Улсын секторын НБББОУСтандартын 17 заалтыг үндэслэн “Ээжээ сайн байна уу” хүрэл хөшөөг үндсэн хөрөнгөд бүртгэх
5	Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй газрыг үнэлж нэмж бүртгэх тухай	Захирал Ш.Алтантуяа Санхүү албаны дарга Д.Байгальмаа		Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 заалт, Улсын секторын НБББОУСтандартын 17 заалтыг тус тус зөрчиж байна. Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 79,723м <sup>2</sup> талбайд 1,364м <sup>2</sup> –ийг дахин үнэлж үндсэн хөрөнгөд бүртгэх
6	Тээврийн хэрэгслийн техник ашиглалтын паспортыг тухай бүрт хөтлөх тухай.	Захирал Ш.Алтантуяа Санхүү албаны дарга Д.Байгальмаа		Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дэх заалтыг зөрчиж байна. 6-н тээврийн хэрэгслийн хувийн хэргийн хөтлөлт хангалтгүй, 5-н тээврийн хэрэгслийн хувийн хэрэг байхгүй байна. Бүртгэлийг тухай бүрт нь хөтлөх.
7	Газартай холбоотой асуудал	Захирал Ш.Алтантуяа Санхүү албаны дарга Д.Байгальмаа		ЭХЭМТ-ийн “Гурван гал” эмнэлгийн авто машины зогсоолын газрыг түрээслүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах.
Нийт зөрчлийн дүн /мян.төг/			765,362.44	